

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХӨДӨӨ АЖ АХУЙ ИХ СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/81/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор:Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 51-261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Аудитор:Д.Батчимэг Утас: 51-261885 Цахим хаяг: batchimegda@ audit.gov.mn Ашид баланс Аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг Утас:99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУСАУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	14
2.5 Аудит хийсэн эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	17
3.5 Зорилгот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	19
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	20
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн	21
4.4.1 Шилэн	21
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар	22
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Албан шаардлага	24
5.3 Зөвлөмж	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	308
Товчилсон үгийн жагсаалт	
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АЭС	Агро экологийн сургууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
МААБС	Мал аж ахуй биотехнологийн сургууль
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УСННБОС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОР Б.БААСАНСҮХ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.27 № 06/828
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,673.7 сая төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Олон жилийн насжилттай 2014-2016 онуудад үүссэн нийт 696.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Нэр бүхий 3 байгууллагад үндсэн хөрөнгө, бараа материал бэлтгэхэд 55.2 сая төгрөгийг шилжүүлж, урьдчилж гарсан зардалд бүртгэсэн боловч жилийн эцэст тооцоо хийж, хөрөнгийг орлогод бүртгээгүй;
- Тайлант онд 371.5 сая төгрөгийн хичээл, дадлагын өрөөний тавилга эд хогшилд нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн;
- Санхүүгийн тайланд нийт 99.5 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10 дугаар зүйлийн 10.5, 32 дугаар зүйлийн 32.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь

заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка) хоорондын зээлийн хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлж буй Инженер, технологийн дээд боловсрол төслийн санхүүжилтээр бий болсон 72 нэр төрлийн нийт 2,647.5 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны 11 дүгээр тогтоолын дагуу санхүүгийн тайланд тусгасан байна.

Тус сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 1214 нэр төрлийн 1,384.9 сая төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 626 дугаар тогтоолыг үндэслэн акталж, данс бүртгэлээс хассан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус сургуулийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 1,800.0 сая төгрөгийн өртөгтэй Олон улсын хэл судлалын төвийн барилга, Эдийн засаг, бизнесийн сургуулийн номын сангийн өргөтгөлийн барилга нь Ковид цар тахлын улмаас барилгын материалын үнэ нэмэгдсэн, шүүхийн маргаантай зэрэг шалтгаанаар ажил нь зогсож, цаашид төрийн өмч хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, барилга бүрэн баригдаж дуусахгүй байх эрсдэлтэй үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хөдөө аж ахуйн их сургуулийн 6 бүрэлдэхүүн сургууль, захиргаа, лицей сургуулиуд нь санхүүгийн unicus программыг ашигладаг, Баянхонгор, Дархан-Уул аймгийн салбар сургуулиуд нь санхүүгийн өөр программ ашиглагдагасан санхүүгийн нэгтгэл тайланг эксел хүснэгт ашиглан нэгтгэж байна.

Тус сургууль нь санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанаас 12 хоног хоцроож, 2026 оны 2 дугаар сарын 27-нд ирүүлж, аудитын үйл ажиллагаанд хүндрэл учруулсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten signature] Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,205,007,477.24	11,363,066,295.52
31	МӨНГӨ ХӨРӨНГӨ	3,130,707,679.80	6,276,254,062.98
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	3,130,707,679.80	6,276,254,062.98
31210	Төгрөг	2,627,160,958.76	5,760,409,379.82
31213	Арилжааны банк дахь харилцах төгрөг	2,627,160,958.76	5,760,409,379.82
31220	Гадаад валют	503,546,721.04	515,844,683.16
31224	Арилжааны банк дахь харилцах валют	503,546,721.04	515,844,683.16
33	АВЛАГА	2,211,463,535.05	2,099,130,493.05
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	299,433,622.82	218,537,796.11
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	899,510,196.00	1,138,950,530.00
33500	Бусад авлага	1,022,519,716.23	741,642,166.94
33510	Байгууллагаас авах авлага	545,125,916.23	492,377,626.94
33520	Хувь хүмүүсээс авах авлага	477,393,800.00	249,264,540.00
34	УРЬДЧИЛГАА	2,081,853,544.26	906,447,207.93
34600	Урьдчилж төлсөн зардал	1,208,529,972.13	76,676,286.21
34710	Урьдчилгаа тооцоо	873,323,572.13	829,770,921.72
34711	Бараа материал, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	110,497,129.80	224,006,114.21
34712	Төсөл хөтөлбөрийн тооцоо	639,058,580.51	605,764,807.51
34713	Цалингийн урьдчилгаа	81,194,533.13	-
34714	Томилолтын урьдчилгаа	42,573,328.69	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,780,982,718.13	2,081,234,531.56
35100	Түүхий эд материал	4,430,949.20	9,974,519.20
35110	Тусгай зориулалтай материал	4,430,949.20	9,974,519.20
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	66,290,000.00	67,091,400.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн/ хангамжийн материал шаардахаар зарлагдах	78,362,369.12	968,877.05
35400	Хангамжийн материал	1,591,186,407.63	1,969,229,457.42
35410	Бичиг хэргийн материал	10,707,523.77	31,049,964.39
35420	Аж ахуйн материал	1,545,988,895.76	1,408,704,652.37
35430	Сэлбэг хэрэгсэл	18,924,400.00	11,781,900.00
35440	Түлш, шатах тослох материал	3,683,762.39	4,260,567.97
35450	Барилгын засварын материал	11,671,825.71	58,864,161.51
35460	Хүнсний материал	200,000.00	2,615,000.00
35470	Бусад хангамжийн материал		451,911,411.18
35600	Мал амьтад	40,712,992.18	33,970,277.89
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	56,282,453,723.11	61,392,778,668.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	56,282,453,723.11	61,392,778,668.67
39200	Биет хөрөнгө	33,141,028,954.49	38,266,511,216.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	32,138,144,489.71	35,652,640,389.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,438,675,060.84)	(8,436,010,282.33)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,170,275,428.92	1,465,321,403.92
39205	Машин, тоног төхөөрөмж	15,381,533,852.05	18,402,797,023.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,930,774,954.60)	(11,700,946,335.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,029,689,190.05	3,160,831,002.14

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,279,760,236.91)	(2,322,280,095.66)
39214	Худаг услалтын систем	116,710,013.00	118,279,813.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(55,611,677.19)	(62,144,858.23)
39216	Дуусаагүй барилга байгууламж	1,800,514,611.00	1,800,514,611.00
39217	Ном	1,109,304,238.58	1,129,456,797.48
39300	Биет бус хөрөнгө	23,141,424,768.62	23,126,267,451.98
39301	Программ хангамж	226,853,600.00	196,873,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(168,211,844.69)	(146,806,161.35)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,754,633,200.00	360,149,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(38,172,266.69)	(18,737,866.67)
39305	Газар	21,366,322,080.00	22,734,789,080.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	65,487,461,200.35	72,755,844,964.19
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,713,186,126.56	1,924,583,384.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,713,186,126.56	1,924,583,384.22
41300	Өглөг	940,844,299.62	767,592,681.43
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	157,206,925.79	97,140,258.38
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11,986,838.09	208,781,333.26
41360	Бусад өглөг	370,726,154.66	95,175,595.06
41361	Байгууллагад өгөх өглөг	269,499,946.00	30,328,805.57
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	101,226,208.66	64,846,789.49
41370	Банкны зээлийн өглөг	-	-
41380	Татвар, НДШ-ий өглөг	400,924,381.08	366,495,494.73
41400	Урьдчилж орсон орлого	5,772,341,826.94	1,156,990,702.79
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	4,601,037,490.00	610,516,387.00
41440	Бусад УОО	1,171,304,336.94	546,474,315.79
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	58,774,275,073.79	70,831,261,579.97
51	Засгийн газрын хувь оролцоо	58,774,275,073.79	70,831,261,579.97
51100	Засгийн газрын оруулсан капитал	33,715,894,283.70	33,715,894,283.70
51101	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	33,715,894,283.70	33,715,894,283.70
51200	Хуримтлагдсан үр дүн	5,969,894,006.12	18,220,874,413.00
51210	Өмнөх үеийн үр дүн	(4,752,159,109.10)	6,175,045,100.67
51220	Тайлант үеийн үр дүн	10,722,053,115.22	12,045,829,312.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,088,486,783.97	18,894,492,883.27
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	65,487,461,200.35	72,755,844,964.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	42,220,792,141.55	49,564,002,021.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,889,916,326.55	49,519,342,395.48
120	Нийтлэг татварын бус орлого	41,680,376,326.55	49,518,442,395.48
120002	Хүүгийн орлого	18,927,540.33	149,179,874.32
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	35,935,677,915.86	46,027,217,421.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,892,347,084.95	34,555,576,733.22
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,646,787,991.93	2,746,346,308.52
1200043	Боловсролын зээлийн сангийн санхүүжилт	2,300,862,389.00	1,681,928,403.43
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,200,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	10,047,326,380.00	7,024,179,722.98
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	48,354,069.98	17,986,253.62
120005	Түрээсийн орлого	-	7,107,802.64
120009	Бусад орлого	5,725,770,870.36	3,334,937,296.75
122	Тусламжийн орлого	209,540,000.00	900,000.00
122001	Хандив тусламж /дотоод	209,540,000.00	900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330,875,815.00	44,659,626.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	330,875,815.00	44,659,626.50
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	314,359,815.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	16,516,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,235,160,946.73	37,471,952,122.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,235,160,946.73	37,471,952,122.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,501,450,683.84	37,010,606,251.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	15,747,218,516.59	19,126,005,740.49
210101	Үндсэн цалин	9,819,315,427.73	12,742,095,070.98
210102	Нэмэгдэл цалин	5,256,082,164.34	5,812,054,099.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	671,820,924.52	571,856,569.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,952,598,146.48	2,332,568,712.60
210201	Тэтгэврийн даатгал	1,198,246,659.89	1,484,119,597.37
210202	Тэтгэмжийн даатгал	194,395,859.45	175,781,508.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	99,823,717.23	240,246,566.59
210204	Ажилгүйдлийн даатгал	90,836,626.98	85,959,044.23
210205	Эрүүл мэндийн даатгал	369,295,282.93	346,461,995.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,453,504,296.43	1,468,078,469.35
210301	Гэрэл, цахилгаан	585,744,156.67	750,543,789.28
210302	Түлш, халаалт	485,794,019.47	382,966,489.14
210303	Цэвэр, бохир ус	381,966,120.29	334,568,190.93

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	833,008,550.95	728,272,949.58
210401	Бичиг хэрэг	121,774,008.86	133,535,374.58
210402	Тээвэр, шатахуун	62,731,081.74	59,043,249.28
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,037,187.08	58,364,343.01
210404	Ном, хэвлэл	976,200.00	19,660,507.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн урсгал, ариутгал	33,158,600.00	54,698,903.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	157,438,835.88	218,276,354.68
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	63,998,934.54	106,156,725.35
210408	Бараа материал акталсан зардал	333,998,537.44	5,678,396.97
210409	Бараа материал худалдан авахад төлсөн	6,895,165.41	72,859,095.61
2105	Нормативд зардал	28,870,110.67	45,135,286.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	398,306.67	205,980.00
290502	Хоол, хүнс	5,759,874.00	4,009,771.00
290503	Нормын хувцас, нормын цай сүү	22,711,930.00	40,919,535.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	487,464,873.32	1,228,087,995.05
210601	Багаж, техник, хэрэгслийн засвар	33,902,925.00	60,480,013.54
210602	Тээврийн хэрэгслийн засвар, сэлбэг	19,142,650.00	34,009,632.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	674,000.00	2,423,760.00
210604	Урсгал засвар	433,745,298.32	1,131,174,589.51
2107	Томилолт, зочны зардал	236,113,616.00	384,458,759.97
210701	Гадаад албан томилолт	106,911,369.00	262,928,277.97
210702	Дотоод албан томилолт	106,120,990.00	103,407,475.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	23,081,257.00	18,123,007.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,648,169,771.74	6,840,419,293.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	226,966,600.78	4,016,718,341.82
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	76,565,833.10
210803	Даатгалын үйлчилгээ		4,632,632.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,640,511.00	10,163,782.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,624,134.14	7,213,258.00
210807	Газрын төлбөр	198,327,466.00	162,003,008.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээ хураамж	4,989,718.99	9,022,800.40
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	31,482,063.80	544,000.00
210810	Гадаад, дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	2,755,772.34	-
210811	Элсэлт, төгсөлттэй холбоотой зардал	5,060,100.00	20,583,024.00
210813	Харуул хамгаалалтын зардал	91,915,000.00	109,365,000.00
210814	Бусад төлбөр, хураамж татвар	1,747,516,842.04	103,823,416.69
210817	Төсөл хөтөлбөрийн зардал	2,012,049,224.93	2,122,095,912.56
210819	Бусад төсөл ШУТ сан	320,320,337.72	197,688,285.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,114,502,801.66	4,857,579,044.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	734,229,957.76	438,660,140.28
210902	Хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагатай холбоотой зардал	520,057,956.76	459,152,881.38
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,856,320,458.14	2,969,251,447.32
210905	Мэдээлэл сурталчилгааны зардал	75,064,276.52	120,091,748.48
210906	Оюутны тэтгэлэг, хөнгөлөлт, урамшуулал	609,369,881.00	435,032,091.50

210907	Оюутны спорт, урлагийн арга хэмжээ	89,449,085.00	160,630,763.00
210908	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	172,870,887.48	192,957,277.65
210909	Мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар	57,140,299.00	81,802,695.00
211	ХҮҮ	470,122,402.13	230,838,084.56
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	470,122,402.13	230,838,084.56
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	470,122,402.13	230,838,084.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	263,587,860.76	230,507,786.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	263,587,860.76	230,507,786.04
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	224,013,138.76	141,861,872.04
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,574,722.00	88,645,914.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	10,985,631,194.82	12,092,049,899.56
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,648,902.30	21,767,679.77
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,648,902.30	21,767,679.77
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	267,226,981.90	67,988,267.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	202,051,230.71	9,300,581.94
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	33,734,034.00
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	65,175,751.19	24,953,651.06
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	10,722,053,115.22	12,045,829,312.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	34,089,005,747.78	40,991,529,890.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,758,129,932.78	38,250,100,563.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,754,256,432.78	38,248,000,563.00
120002	Хүүгийн орлого	21,721,577.31	149,179,874.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,032,667,747.23	35,789,183,594.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,740,022,526.00	31,347,783,440.19
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,416,994,512.68	2,759,471,750.77
1200043	Боловсролын зээлийн сангийн орлого	2,555,443,529.00	1,681,928,403.43
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	4,320,207,179.55	-
120005	Түрээсийн орлого	-	52,741,000.00
120009	Бусад орлого	699,867,108.24	2,256,896,094.29
122	Тусламжийн орлого	3,873,500.00	2,100,000.00
122001	Хандив тусламж/дотоод	3,873,500.00	2,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330,875,815.00	44,698,080.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	330,875,815.00	44,659,626.50
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	314,359,815.00	44,659,626.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	16,516,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	38,454.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	38,454.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,013,698,055.05	34,534,980,034.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,013,698,055.05	34,534,980,034.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,333,306,504.60	34,004,174,831.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	15,386,802,094.46	18,583,827,556.51
210101	Үндсэн цалин	15,386,802,094.46	18,583,539,556.51
210105	Гэрээт ажлын хөлс	-	288,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,046,491,654.84	2,754,864,657.31
210201	Тэтгэврийн даатгал	2,890,832,107.64	2,644,670,071.02
210205	Эрүүл мэндийн даатгал	155,659,547.20	110,194,586.29
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	1,508,577,420.15	1,501,974,414.93
210301	Гэрэл, цахилгаан	610,256,596.26	752,359,892.06
210302	Түлш, халаалт	511,448,535.00	412,123,176.51
210303	Цэвэр, бохир ус	386,872,288.89	337,491,346.36
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	577,673,210.74	748,636,953.31
210401	Бичиг хэрэг	134,345,655.00	98,762,486.00

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	34,242,334.00	56,071,818.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,602,670.96	63,029,943.01
210404	Ном, хэвлэл	18,553,300.00	40,023,516.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,321,600.00	51,477,523.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	119,317,446.48	181,990,667.64
210407	Цахилгааны материал, засвар	51,665,510.00	72,841,550.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	24,717,494.00	30,657,432.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	109,907,200.30	153,782,017.66
2105	Нормативд зардал	42,111,955.00	45,035,348.06
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,695,885.00	790,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,416,070.00	44,244,918.06
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	461,455,700.64	1,504,609,461.42
210601	Багаж, техник, хэрэгслийн засвар	101,591,710.00	176,960,132.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	108,000.00
210604	Урсгал засвар	359,863,990.64	1,327,541,328.82
2107	Томилолт, зочны зардал	634,649,831.03	369,533,583.38
210701	Гадаад албан томилолт	419,468,475.48	247,233,036.38
210702	Дотоод албан томилолт	193,219,678.55	102,818,559.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	21,961,677.00	19,481,988.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,577,664,609.32	6,461,338,001.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	1,333,630,886.36	2,867,294,535.61
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	51,400,000.00	76,566,014.10
210803	Даатгалын үйлчилгээ	-	23,164,692.29
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,469,729.00	3,741,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	818,250.00
210807	Газрын төлбөр	190,643,464.00	178,477,770.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,233,812.56	7,501,273.15
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	500,000.00
210810	Гадаад, дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	199,888,462.11	57,878,052.24
210811	Элсэлт, төгсөлттэй холбоотой зардал	43,671,191.00	117,061,050.38
210813	Харуул хамгаалалтын зардал	60,415,000.00	109,365,000.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	124,875,848.21	147,263,699.77
210817	Төсөл хөтөлбөрийн зардал	1,968,039,287.06	2,598,575,742.20
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	336,990,730.00	1,932,000.00
210819	Бусад төсөл ШУТ сан	262,406,199.02	271,197,942.08
2109	Бараа үйлчилгээний бусад зарлал	1,097,880,028.42	2,034,354,855.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,134,590.61	217,067,449.18
210902	Хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагатай холбоотой зардал	529,548,490.86	627,100,100.25
210905	Мэдээлэл сурталчилгааны зардал	71,645,156.82	96,071,705.45
210906	Оюутны тэтгэлэгт, хөнгөлөлт, урамшуулал	16,816,860.00	582,444,657.50
210907	Оюутны спорт, урлагийн арга хэмжээ	48,583,589.00	155,189,464.00

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210908	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	165,160,706.13	260,296,423.70
210909	Мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар	90,990,635.00	96,185,055.00
211	ХҮҮ	435,426,968.34	241,983,304.95
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	435,426,968.34	241,983,304.95
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	435,426,968.34	241,983,304.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,964,582.11	288,821,897.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,964,582.11	288,821,897.23
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7,603,769.74	-
213207	Тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	182,366,397.37	202,431,721.23
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,994,415.00	86,390,176.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,075,307,692.73	3,759,818,609.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	694,750,463.78	636,039,906.09
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	694,750,463.78	636,039,906.09
2200	Дотоод эх үүсвэрээр	694,750,463.78	636,039,906.09
220001	Барилга байгууламж	262,971,834.00	19,950,000.00
222001	Тавилга эд хогшил	103,318,259.78	131,050,016.21
222002	Техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж	271,406,178.00	190,426,688.82
222004	Программ хангамж	-	-
223001	Бусад хөрөнгө	100,000.00	24,953,651.06
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,954,192.00	269,659,550.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(694,750,463.78)	(636,039,906.09)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(3,232,190,660.33)	21,767,679.77
14	Бусад эх үүсвэр	5,744,304,109.59	3,208,656,782.01
145007	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	5,744,304,109.59	3,208,656,782.01
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	8,976,494,769.92	3,213,110,897.76
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	64,927,964.92	13,110,897.76
250002	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	8,911,566,805.00	3,200,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,148,366,568.62	3,145,546,383.18
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	982,341,111.18	3,130,707,679.80
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,130,707,679.80	6,276,254,062.98

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцоо нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	33,715,894,283.70	19,088,486,783.97	(4,752,159,109.10)	48,052,221,958.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,715,894,283.70	19,088,486,783.97	(4,752,159,109.10)	48,052,221,958.57
Тайлангийн үеийн үр дүн	-	-	10,722,053,115.22	10,722,053,115.22
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	33,715,894,283.70	19,088,486,783.97	5,969,894,006.12	58,774,275,073.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(193,993,900.70)	205,151,094.55	11,157,193.85
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,715,894,283.70	18,894,492,883.27	6,175,045,100.67	58,785,432,267.64
Тайлангийн үеийн үр дүн	-	-	12,045,829,312.33	12,045,829,312.33
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	33,715,894,283.70	18,894,492,883.27	18,220,874,413.00	70,831,261,579.97

2.5 Аудит хийсэн эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
A	Бакалаврын оюутны тоогоор	тоо	5,481	6,000	5,896	(104)	98
	Магистр, доктор тоогоор	тоо	1557	1,700	1,740	40	102
Б	НИЙТ ОРЛОГО	мян.төг	26,626,800.0	39,145,892.0	42,521,836.0	3,375,944.0	109
	Сургалтын төлбөрийн орлого	мян.төг	22,059,600.0	29,738,038.5	32,849,586.3	3,111,548.0	110
	Магистр доктор орлого	мян.төг	815,100.0	2,154,809.0	3,537,984.6	1,383,176.0	164
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	мян.төг	1,377,900.0	2,950,960.0	2,746,346.3	(204,614.0)	93
	Төсөл хөтөлбөрийн орлого	мян.төг	2,370,300.0	2,596,252.5	3,387,918.8	791,666.0	130
	Үнэ төлбөргүй орлого	мян.төг	3,900.0	1,705,832.0	-	(1,705,832.0)	-
В	НИЙТ ЗАРДАЛ	мян.төг	19,560,600.0	37,660,989.0	37,471,952.1	(189,037.0)	99
	Сургалттай холбоотой зардал	мян.төг	16,356,200.0	25,054,234.8	23,604,800.9	(1,449,434.0)	94
1	Цалин хөлс, НДШ	мян.төг	14,886,700.0	22,154,142.1	21,458,574.5	(695,568.0)	97
2	Тогтмол зардал	мян.төг	1,009,800.0	1,878,632.0	1,468,078.5	(410,554.0)	78
3	Интернет, шуудан холбоо	мян.төг	34,900.0	72,774.6	58,364.3	(14,410.0)	80
4	Хичээлийн үйлдвэрлэл, дадлага сургуулилт	мян.төг	346,100.0	735,334.5	459,152.9	(276,182.0)	62
5	Оюутны арга хэмжээ	мян.төг	78,700.0	213,351.6	160,630.8	(52,721.0)	75
	Сургалтын шууд бус зардал	мян.төг	3,204,400.0	12,606,754.2	13,867,151.2	1,260,397.0	110
1	Урсгал зардал	мян.төг	516,200.0	7,100,455.7	6,405,547.3	(694,908.0)	90
2	Элсэлттэй холбоотой зардал	мян.төг	49,600.0	387,410.0	20,583.0	(366,827.0)	5
3	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	мян.төг	170,800.0	324,064.4	88,645.9	(235,418.0)	27
4	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	мян.төг	33,700.0	14,500.0	141,861.9	127,362.0	978
5	Төсөл хөтөлбөрийн зарцуулалт	мян.төг	668,700.0	1,620,681.7	2,122,095.9	501,414.0	131
6	Банкны зээлийн хүүгийн зардал	мян.төг	454,100.0	220,384.9	230,838.1	10,453.0	105
7	Бусад	мян.төг	1,311,300.0	2,939,257.5	4,857,579.0	1,918,321.0	165
Г	Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз (гарз)	мян.төг	382,100.0	627,600.0	46,200.0	(581,000.0)	7
Д	ҮЙЛ АЖИЛЛАГААН Ы ҮР ДҮН	мян.төг	6,684,100.0	857,303.0	5,003,684.0	4,146,381.0	584

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн их сургууль нь эрхэм зорилгоо “Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн чиглэлээр шинжлэх ухаан, сургалт, үйлдвэрлэлийн хосолсон бүс нутгийн тэргүүлэх их сургууль болоход оршино” гэж тодорхойлсон байна.

Тус сургуулийн дүрэмд үйл ажиллагааны чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, технологийн онолын болон хэрэглээний судалгаа, шинэ мэдлэг бүтээх, судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа;
- Мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, инженер, технологи, эдийн засаг, бизнесийн удирдлага, мэдээллийн систем, хүрээлэн буй орчин, газрын харилцаа, байгалийн аялал жуулчлалын чиглэлээр бакалавр, магистр, докторын зэрэг олгох шаталсан сургалт;
- Мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт;
- Технологи дамжуулалт, өндөр технологийн үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаа;
- Инновацын хуулийн хүрээнд гарааны компаниудыг байгуулах, хөгжүүлэлт;
- ХААИС-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу дотоод, гадаадын харилцан ашигтай хамтын ажиллагаа, их сургууль-үйлдвэрлэлийн түншлэл.

Хөдөө аж ахуйн их сургуулийн дүрэмд зааснаар өмчийг 100 хувь төр эзэмшиж байгаа бөгөөд төрийн өмчийн төлөөллийг Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлэхээр заасан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөө аж ахуйн дээд сургуулийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн хурлын 95/104 дүгээр тогтоолоор байгуулж, Засгийн газрын 1990 оны 114 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуйн их сургууль болгон өөрчилсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Сургуулийн удирдлагыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасны дагуу Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны 06 сарын 05-ны өдрийн Б/60 тушаалаар Б.Баасансүхийг захирлаар томилсон байна.

Тус сургууль нь үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд сургуулийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Монгол хэлний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн батлагдсан байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Захирлын 2025 оны А/211 тоот тушаалаар “Дотоод аудитын журам”-ыг баталсан боловч тайлант хугацаанд батлагдсан орон тоонд дотоод аудитор ажиллаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилгот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус их сургууль нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, сургуулийн үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай”;

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,268.4 сая төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,130,707.7	6,276,254.1	3,145,546.4
Авлага	2,211,463.5	2,099,130.5	(112,333.0)
Урьдчилгаа	2,081,853.5	906,447.2	(1,175,406.3)
Бараа материал	1,780,982.7	2,081,234.5	300,251.8
Үндсэн хөрөнгө	56,282,453.8	61,392,778.7	5,110,324.9
Нийт хөрөнгийн дүн	65,487,461.2	72,755,845.0	7,268,383.8
Өр төлбөр	6,713,186.1	1,924,583.4	(4,788,602.7)
Засгийн газрын хувь оролцоо	58,774,275.1	70,831,261.6	12,056,986.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	65,487,461.2	72,755,845.0	7,268,383.8

Дээрх хүснэгтээс үзэхэд мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцооны данстуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 6,276.3 сая төгрөг болж өмнөх оноос 3,145.5 сая төгрөгөөр өссөн нь оюутны тоо, кредит цагийн үнэлгээ нэмэгдсэнээр, сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 12.3 хувиар нэмэгдсэн нөлөөлсөн байна. Хаан банканд 2,107.9 сая төгрөг, Голомт банкны 2,192.4 сая төгрөг, Төрийн банканд 214.1 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банканд 16.1 сая төгрөг, Капитрон банканд 245.8 сая төгрөг, М банк 1,500.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй.
- Авлага дансны үлдэгдэл 2,099.1 сая төгрөг болж өмнөх оноос 112.3 сая төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлага 52.7 сая төгрөг, ажиллагсадтай холбоотой авлага 80.9 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 228.1 сая төгрөг нийт 361.7 сая төгрөгөөр тус тус буурч, төлбөртэй үйлчилгээний авлага 249.5 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 906.4 сая төгрөг болж өмнөх оноос 1,175.4 сая төгрөгөөр буурсан нь бараа материал, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа зардал 113.5 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн тооцоо 33.3 сая төгрөг, цалин, томилолтын урьдчилгаа 123.8 сая төгрөг, урьдчилж төлсөн зардал 1,131.8 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн.
- Бараа материалын үлдэгдэл 2,081.2 сая төгрөг болж өмнөх оноос 300.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 1,999.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 26.1 сая төгрөг, данс хооронд шилжсэн 15.6 сая төгрөгийн бараа материал нөлөөлсөн.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 61,392.8 сая төгрөг болж өмнөх оноос 5,110.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 607.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, ТӨБЗГ-ын 2026 оны 11 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/ хоорондын зээлийн хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлж

буй “Инженер технологийн дээд боловсрол” төслийн санхүүжилтээр бий болсон 72 нэр төрлийн, нийт 2,647.5 сая төгрөг тоног төхөөрөмж, Барилга байгууламжийн ашиглалтад оруулах тухай улсын комиссын 2023 оны БА-111/2023 дүгнэлт, ХААИС-ийн 2023 оны А/220 дугаар тушаалыг үндэслэн Мал амьтны эмнэлгийн 3,936.0 сая төгрөгийн өртөгтэй барилгыг тус тус үндсэн хөрөнгөд бүртгэж, ТӨБЗГ-ын 2025 оны 626 дугаар тушаалаар элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 1214 нэрийн, нийт 1,384.9 сая төгрөгийг хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан нь голлон нөлөөлж байна.

- Өр төлбөрийн үлдэгдэл 1,924.6 сая төгрөг болж, 4,788.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгууллагад төлөх өр төлбөр 239.2 сая төгрөг, банкны зээл 3,200.0 сая төгрөг төлөгдсөн, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн төлж барагдуулснаас шалтгаалсан.
- Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл 12,057.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр тогтоолоор 2025 оны орлогын төлөвлөгөөг 39,145.9 сая төгрөг, зардлын төлөвлөгөөг 37,661.0 сая төгрөгөөр баталсан байна.

Тус сургуулийн санхүүжих эх үүсвэрийн сургалтын төлбөрийн орлого 29,738.0 сая төгрөг, магистр, докторын орлого 2,154.8 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого бүрэлдэхүүн сургуулийн үйл ажиллагааны орлого 2,951.0 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн орлогоос 2,596.3 сая төгрөг, үнэ төлбөргүй орлого 1,705.8 сая төгрөг нийт 39,145.9 сая төгрөгийг бүрдүүлэх, сургалттай холбоотой цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, хичээл үйлдвэрлэл, дадлага сургуулилт, оюутны арга хэмжээ, тогтмол зардал 25,054.2 сая төгрөг, сургалтын шууд бус зардал болох элсэлттэй холбоотой зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, төсөл хөтөлбөр, банкны зээлийн хүүгийн зардалд 12,606.8 сая төгрөг, нийт 37,661.0 сая төгрөгийг зарцуулахаар тус тус төсөвлөж, баталсан байна.

Гүйцэтгэлээр сургалтын төлбөрийн орлогоос 32,849.6 сая төгрөг, магистр, докторын сургалтын төлбөрийн орлого 3,538.0 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 2,746.3 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн орлого 3,387.9 сая төгрөг, нийт 42,521.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,375.9 сая төгрөгөөр давсан нь тайлант онд шинэ элсэгчдийн тоо нэмэгдэж, кредит цагийн үнэлгээ 10-13 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд нийт 37,472.0 сая төгрөгийн зардал гарсан нь төлөвлөсөн хэмжээнээс 189.0 сая төгрөгөөр дутуу буюу 99.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Зардлын гүйцэтгэлд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 696.0 сая төгрөг, тогтмол зардал 411.0 сая төгрөг, интернэт шуудан холбооны зардал 14.0 сая төгрөг, хичээлийн үйлдвэрлэл, дадлага сургуулийн зардал 276.0 сая төгрөг, оюутны арга хэмжээний зардал 53.0 сая төгрөг, урсгал зардал 695.0 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

Судалгааны үр дүн:

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус сургуулиас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

Тус сургуулийн ректорын 2025 оны А/348 дугаар тушаалаар захиргааны бүтэц дэх нэгжийн харьяалах ажилтны нэрс, албан тушаал, цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталсан байна.

Хөдөө аж ахуйн их сургууль, Үйлдвэрчний эвлэлийн хамтын шийдвэрээр 2023 онд нэг ажилтанд ногдох өдрийн хоол, унааны зардал 120.0 мянган төгрөг олгохоор шийдвэрлэсэн, үнийн дүнд өөрчлөлт ороогүй, тайлант хугацаанд хоол, унааны хөнгөлөлтөд нийт 571.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тус сургууль нь гадаад томиллогод 262.9 сая төгрөг, дотоод томиллогод 103.4 сая төгрөг, хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагад 459.1 сая төгрөг, мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт 81.8 сая төгрөг, эрдэм шинжилгээ, судалгааны зардалд 193.0 сая төгрөгийн тус тус зарцуулсан байна.

Мэдээлэл технологийн үйлчилгээнд 7.2 сая, сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, сурталчилгааны зардалд 120.1 сая төгрөг зарцуулсан байна. Төрд учирсан хохирлын төлбөрийн асуудал байхгүй байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус сургууль 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 1,800.9 сая төгрөгийг тусгасан. Үүнээс барилга байгууламжийн урсгал засвар, тавилга, эд хогшил, сургалтын тоног төхөөрөмж худалдан авахад 968.2 сая төгрөг, бараа, ажил үйлчилгээний нийт зардалд 832.7 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгасан.

Нээлттэй тендер шалгаруулалтаар ЭЗБС-ийн засвар үйлчилгээ, компьютер тоног төхөөрөмжийн 678.2 сая төгрөгийн худалдан авалтыг оны эцэст зарлаж 2026 онд сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Харин хичээл, дадлагын өрөөний тавилга эд хогшилд нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Хөдөө аж ахуйн их сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Хөдөө аж ахуйн их сургууль нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/190 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 31,502.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 315.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сургууль нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажиллаж, өмнөх онтой харьцуулахад дулааны зардал 102.8 сая төгрөг, цэвэр, бохир усны зардал 47.4 сая төгрөг, хангамжийн зардал 104.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 256.9 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Харин орлого өмнөх оноос 5,081.7 сая төгрөг буюу 13.6 хувиар өссөнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын зардал 35 хувиар нэмсэн, цахилгааны үнэ тариф нэмэгдсэн, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн зардал өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,801.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст 49,919.4 сая төгрөгийн 1,243 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 413 сая төгрөгийн 41 гүйлгээ, зарлагын 351.5 сая төгрөгийн 30 гүйлгээ, худалдан авсан бараа ажил үйлчилгээ, санхүүжилтийн мэдээ зэрэг 1,036.5 сая төгрөгийн 111 мэдээлэл, нийт 1,801.0 сая төгрөгийн 182 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч сургуулийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалингийн зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар нийт 8,941.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 68.1 сая төгрөгийн 2 алдааг залруулах, ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөггүй нийт 26 нэр төрлийн 503.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 17.8 сая төгрөгийн дадлага сургалтын 3 барилгын, нийт 521.5 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгч, өмнөх аудитын 339.9 сая төгрөгийн зөрчлийн шийдвэрийн хэрэгжилт, шилэн дансны хуулийн 8,079.6 сая төгрөгийн зөрчлийг жилийн эцэст дахин горим хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 1,122.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 6.8 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, 344.7 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлагын хэрэгжилт болон 770.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 зөвлөмжийн хэрэгжилт бүрэн биелсэн гэж үзлээ.

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	дүн	Тоо	Дүн	хувь
Төлбөрийн акт	3	6,816.4	3	6,816.4	100.0
Албан шаардлага	4	344,705.4	4	344,705.4	100.0
Зөвлөмж	5	770,839.5	5	770,839.5	100.0
Нийт дүн	12	1,122,361.4	12	1,122,361.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар доорх асуудлуудад горим сорил гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

Тус сургуулийн олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтарч хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Бүгд Найрамдах Солонгос Улсын Копиа-Монгол төвийн хамтарсан “Монгол орны нөхцөлд тохиромжтой ферментжүүлсэн багсармал тэжээлийг нутагшуулах” төсөл 344.7 сая төгрөг;
- НҮБ-ийн Хамтын ажиллагааны байгууллагатай хамтарсан PO9573648 “Бэлчээрийн маллагаатай Монгол малын махны чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлж зэрэглэл тогтоох үндэслэл гаргах” төсөл 213.0 сая төгрөг;
- AFACI Азийн орнуудын “Хүнсний найрлагын мэдээллийн сан байгуулах” төсөл 123.4 сая төгрөг;
- АНУ-ын “Хүн малын дунд халдвар дамжих хэлхээ, зооноз өвчний халдварын загварчлалыг сайжруулах шинэ арга” төсөл 155.1 сая төгрөг;
- ХБНГУ-ын Волксваген сан, Эберсвалдын тогтвортой хөгжлийн их сургууль Филиппин улсын Плаваны их сургууль Зооноз өвчлөл ба соёлын хувьсал “ZOOMAP” төсөл 101.9 сая төгрөгийн төсөл.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,673.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 5.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,129.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 539.5 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 9 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 1,673.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 315.0 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалтай” дүгнэлт өглөө.

5.1. Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Албан хаагчдын гадаад, дотоод томилолтоор ажилласан хугацаанд 5.2 сая төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Давхардуулж олгосон хоол, унааны мөнгө 5.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Ажлаас чөлөөлөгдсөн нэр бүхий 12 ажилтнаас авах 5.8 сая төгрөгийн цалингийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий 12 ажилтан албан хаагчтай холбоотой цалингийн авлагыг барагдуулах, ажлаас чөлөөлөгдсөн ажилчидтай тооцоо хийгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Тус сургуулийн 2014-2016 онуудад үүссэн тус сургуулийн өмнөх захиралтай холбоотой 461.6 сая төгрөг, Стройка ХХК-ийн 151.5 сая төгрөг, Соёмбо групп ХХК-ийн 83.5 сая төгрөг, нийт 696.6 сая төгрөгийн авлага нь эзэн холбогдогч нь нас барсан, хаяг байршилдаа байхгүй, тодорхой бус гэсэн шалтгаанаар авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 "маргаантай асуудлаар үйлдвэрийн газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эзэн холбогдогч нь нас барсан, хаяг байршилдаа байхгүй, тодорхой бус гэсэн шалтгаанаар авлагыг барагдуулаагүй байгаа зөрчлийг хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх ажил гүйлгээг гарахаас өмнө хянадаггүй, төлбөрийг шилжүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Нэр бүхий 3 байгууллагад үндсэн хөрөнгө, бараа материал бэлтгэхэд 55.2 сая төгрөгийг шилжүүлж, урьдчилж гарсан зардалд бүртгэсэн боловч жилийн эцэст тооцоо хийж, хөрөнгийг орлогод бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгө, бараа материал бэлтгэхтэй холбоотой урьдчилж гарсан зардлын дансны тооцоо хийдэггүй, хөрөнгийг бүртгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Тус сургуулийн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулахаар төлөвлөсөн 371.5 сая төгрөгийн хичээл, дадлагын өрөөний тавилга эд хогшилд нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10 дугаар зүйлийн 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 32 дугаар зүйлийн 32.1 "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5: ХААИС нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр 01/190 дүгээр албан бичгийн хамт аудитын байгууллагад 12 хоногоор хугацаа хоцруулж ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж тайлагнахгүй байгаа зөрчлийн таслан зогсоох, хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Илрүүлэлт 1: М банканд 2025 онд 6 сарын хугацаатай жилийн 14 хувийн хүүтэй 1,500.0 сая төгрөгийг хадгаламжид байршуулснаас 52.0 сая төгрөгийн хүүгийн орлогыг тооцож авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “ үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хадгаламжийн гэрээг үндэслэн санхүүгийн тайлангийн хугацаанд хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэж байх

Илрүүлэлт 2: Тайлант онд 141.9 сая төгрөгийн бараа материал, 34.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу и-баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан, 20 дугаар зүйлийн 20.1.1 "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах байна", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ анхан шатны баримтын иж бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх

Илрүүлэлт 3: Тус сургуулийн нэгдсэн цахилгааны ЦТП-аас ашиглаж байгаа байгууллага, иргэн, ажилчдаас авах авлага 49.3 сая төгрөг, орон сууц ашигласны төлбөр 20.5 сая төгрөг нийт 69.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог

хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Олон жилийн насжилтай авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандах

Илрүүлэлт 4: МААБС-ахлах багшийн амралтын мөнгийг олгохдоо 9.7 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож цалингийн урьдчилгаа дансанд бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Амралтын мөнгө олгохдоо тооцооллыг үнэн зөв хийж хэвших

Илрүүлэлт 5: Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо НБББББ-т тусгагдсан ашиглалтын жилийн хугацааг баримтлаагүйгээс 128.2 сая төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тооцож зардал өсгөсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-д тусгагдсан үндсэн хөрөнгийн заавар журмыг баримтлах, санхүүгийн программын ашиглалтын жилийг хянаж, сайжруулалтыг тогтмол хийж байх

Илрүүлэлт 6: Захиргаа аж ахуйн үйлчилгээний ажилтны 12 сарын нийгмийн даатгалын тайланд 1.8 сая төгрөгийн НДШ-ийн өглөгийг илүү, нэр бүхий 4 ажилтны 2.1 сая төгрөгийн НДШ-ийн өглөгийг дутуу, нийт 3.9 сая төгрөгийн тооцооллын зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сар бүрийн цалингийн тооцоолол, нийгмийн даатгалын тайланд тусгагдсан цалингийн дүн, ажилтны нэрийг тулгаж, үлдэгдлийг баталгаажуулж байх

Илрүүлэлт 7: Агро экологийн сургууль нь бүртгэлийн хураамжийн орлого 32.3 сая төгрөг, бусад орлого 10.4 сая төгрөг, нийт 42.8 сая төгрөгийн татвар ногдох орлогыг, татвараас чөлөөлөгдөх оюутны сургалтын төлбөрийн орлогод нийлүүлж тайлагнасан, ажилчдын орон сууцны түрээсийн орлого 14.8 сая төгрөгийг тайлагнаагүй, Цонхла жигдэн ХХК-ийн цайны газрын 63.5 сая төгрөгийн

түрээсийн орлогоос 41.9 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан, нийт 99.5 сая төгрөгийн орлого дутуу тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 23 дугаар зүйлийн 23.3 "Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу татвар тооцох орлогыг бүрэн тусгаж байх, татвараас чөлөөлөх орлогыг зөв тайлагнаж байх

Илрүүлэлт 8: БШУС-ын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа боловч шинэчлэгдсэн хууль, журмуудын нэмэлт өөрчлөлтийг оруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт болон хуулийн өөрчлөлтийг тусган, төсвөөс нэмэлт зардал гаргахгүйгээр өөрсдийн нөөц бололцоогоор шинэчлэх

Илрүүлэлт 9: Тус сургууль нь 6 бүрэлдэхүүн сургууль, Дархан, Баянхонгор аймагт салбар сургууль, ахлах сургууль, захиргаа гэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг. Санхүүгийн "Unicus" программ ашигладаг боловч нэгтгэл санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн задаргаа харагдахгүй, тайлант хугацааны санхүүгийн тайлангийн хаалт хийдэггүй, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход хөрөнгийн сонголтгүй, бараа материал, хөрөнгийн дотоод хөдөлгөөн тусдаа модулаар бүртгэдэггүй, хөрөнгө, бараа материалын дансны хооронд шилжүүлэх гүйлгээ хийж болдоггүй зэрэг шаардлага хангахгүй байна.

Баянхонгор, Дархан-Уул аймаг дах салбар сургуулиуд нь санхүүгийн өөр программ ашигладгаас нэгтгэл тайланг эксел хүснэгтээр бэлтгэн гаргаж байгаа нь цаг хугацаа алдах, нэгтгэл тайлан алдаатай гарах эрсдэл байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программыг нийтэд мэдээлэх”, 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн программын хөгжүүлэлт, шинэчлэлтийг тогтмол хийж байх, нэгтгэсэн санхүүгийн тайланг нэг программ ашиглаж гаргаж тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	М банканд 2025 оны 10 дугаар сарын 14-нд 6 сарын хугацаатай жилийн 14 хувийн хүүтэй 1,500,000.0 мянган төгрөгийн хадгаламж байршуулснаас тайлант хугацааны эцэст ногдох хүүгийн орлого 52,000.0 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй.	1	52,000.0					1	52,000.0				
2	Бараа материал 141,887.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 34,502.9 мянган төгрөг нийт 176,390.5 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ анхан шатны баримтын иж бүрдэл дутуу и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	176,390.5					1	176,390.5				
3	Тус сургуулийн нэгдсэн цахилгааны ЦТП-аас ашиглаж байгаа байгууллага, иргэн, ажилчдын төлбөрийн авлага 49,290.5 мянган төгрөг, орон сууцны ашигласны төлбөр 20,520.5 мянган төгрөгийн авлагын барагдуулаагүй	1	69,811.0					1	69,811.0				
4	Нэр бүхий 12 ажилтан албан хаагчид ажлаас чөлөөлөгдсөн боловч 5,769.7 мянган төгрөгийн цалингийн авлагын үлдэгдэлтэй байна.	1	5,769.7			1	5,769.7						

5	2014-2016 онуудад үүссэн ХААИС-ийн өмнөх захиралтай холбоотой 461,560.0 мянган төгрөг, Стройка ХХК 151,519.3 мянган төгрөг, Соёмбо групп ХХК 83,500.0 мянган төгрөг нийт 696,579.3 мянган төгрөгийн авлага нь эзэн нь нас барсан, хаяг байршилдаа байхгүй, олдохгүй гэсэн шалтгаанаар авлага барагдаагүй байгаа нь найдваргүй болох эрсдэл үүссэн байна.	1	696,579.3			1	696,579.3					
6	Нэр бүхий 3 байгууллагад үндсэн хөрөнгө, бараа материал бэлтгэхтэй холбоотой 55,220.0 мянган төгрөгийг шилжүүлж урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн боловч жилийн эцэст тооцоо хийж хөрөнгийг орлогод бүртгээгүй байна.	1	55,220.0			1	55,220.0					
7	МАНБС -ахлах багшийн амралтын мөнгийг олгохдоо 9,745.8 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.	1	9,745.8					1	9,745.8			
8	Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо НБББББ-т тусгагдсан ашиглалтын жилийн хугацааг баримтлаагүйгээс 128,173.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тооцож зардал өсгөсөн	1	128,173.7					1	128,173.7			
9	Захиргаа аж ахуйн үйлчилгээний ажилтны 12 сарын нийгмийн даатгалын тайланд 1,809.2 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгийг илүү, нэр бүхий 4 ажилтны 2,063.8 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгийг дутуу тайлагнасан	1	3,873.0					1	3,873.0			
10	АЭС бүртгэлийн хураамжийн орлого 32,357.3 мянган төгрөг, бусад орлого 10,420.2 мянган төгрөг, нийт 42,777.5 мянган төгрөгийн татвар ногдох орлогыг, татвараас чөлөөлөгдөх оюутны сургалтын төлбөрийн	1	99,455.9					1	99,455.9			

	орлогод нийлүүлж тайлагнасан, ажилчдын орон сууцны түрээсийн орлого 14,763.5 мянган төгрөг, Цонхла жигдэн ХХК-ийн цайны газрын 63,531.0 мянган төгрөгийн түрээсийн орлогоос 41,918.0 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан нийт байна												
11	Албан хаагчдын гадаад, дотоод томилолтын хугацаанд 5,194.4 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт давхардуулж олгосон байна.	1	5,194.4	1	5,194.4								
12	БШУСайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны Салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн мөрдөж байгаа боловч шинэчлэгдсэн хууль, журмуудын нэмэлт өөрчлөлтийг оруулаагүй байна.	1						1					
13	Тус сургууль нь 6 бүрэлдэхүүн сургууль, Дархан, Баянхонгор аймагт салбар сургууль, ахлах сургууль, захиргаа гэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг. Санхүүгийн "Unicus" программ ашигладаг боловч нэгтгэл санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн задаргаа харагдахгүй, тайлант хугацааны санхүүгийн тайлангийн хаалт хийдэггүй, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход хөрөнгийн сонголтгүй, бараа материал, хөрөнгийн дотоод хөдөлгөөн тусдаа модулаар бүртгэдэггүй, хөрөнгө, бараа	1						1					

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	материалын дансны хооронд шилжүүлэх гүйлгээ хийж болдоггүй зэрэг шаардлага хангахгүй байна. Баянхонгор, Дархан-Уул аймаг дах салбар сургуулиуд нь санхүүгийн өөр программ ашигладгаас нэгтгэл тайланг эксел хүснэгтээр бэлтгэн гаргаж байгаа нь цаг хугацаа алдах, нэгтгэл тайлан алдаатай гарах эрсдэл байна.												
14	ХААИС-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ээр дуусгавар болгосон Санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 27-нд аудитын байгууллагад 12 хоног хугацаа хоцроож ирүүлсэн.	1				1							
15	Тус сургуулийн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулахаар төлөвлөсөн 371.5 сая төгрөгийн хичээл, дадлагын өрөөний тавилга эд хогшилд нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	371,514.3			1	371,514.3						
Нийт		15	1,673,727.6	1	5,194.4	5	1,129,083.3	9	539,449.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудаст 49,919.4 мянган төгрөгийн 1,243 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 41 мэдээлэл 413,034.9 мянган төгрөг, зарлагын 30 мэдээлэл 351,460.1 мянган төгрөг, худалдан авсан бараа ажил, үйлчилгээ, санхүүжилтийн мэдээ 1,036,492.2 мянган төгрөгийн 111 мэдээлэл, нийт 1,800,987.2 мянган төгрөгийн 182 мэдээллийг байршуулаагүй байна.	1	1,800,987.2	1	1,800,987.2		
	Дүн	1	1,800,987.2	1	1,800,987.2		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 203/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/81/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдын гадаад, дотоод томилолтын хугацаанд 5,194,378.04 /таван сая нэг зуун ерэн дөрвөн мянга гурван зуун далан найман төгрөг дөрвөн мөнгө/ төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулж олгосон хоол, унааны мөнгө 5,194,378.04 /таван сая нэг зуун ерэн дөрвөн мянга гурван зуун далан найман төгрөг дөрвөн мөнгө/ төгрөгийг ерөнхий нягтлан бодогч Г.Нарангэрэлээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дах Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор /Б.Баасансүх/-т хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Л.МАЙЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1059/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/81/НА - СТА -ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст 49,919,417,328.00 /дөчин есөн тэрбум есөн зуун арван есөн сая дөрвөн зуун арван долоон мянга гурван зуун хорин найман/ төгрөгийн 1,243 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 413,034,889.64 /дөрвөн зуун арван гурван сая гучин дөрвөн мянга найман зуун наян есөн төгрөг жаран дөрвөн мөнгө/ төгрөгийн 41 мэдээлэл, 351,460,135.70 /гурван зуун тавин нэгэн сая дөрвөн зуун жаран мянга нэг зуун гучин таван төгрөг далан мөнгө/ төгрөгийн зарлагын 30 мэдээлэл, худалдан авсан бараа ажил, үйлчилгээ, санхүүжилтийн мэдээ зэрэг 1,036,492,215.06 /нэг тэрбум гучин зургаан сая дөрвөн зуун ерэн хоёр мянга хоёр зуун арван таван төгрөг зургаан мөнгө/ төгрөгийн 111 мэдээлэл, нийт 1,800,987,240.00 /нэг тэрбум найман зуун сая есөн зуун наян долоон мянга хоёр зуун дөчин/ төгрөгийн 182 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хуульд заасан хугацаанд тухай бүр тогтмол мэдээлэхгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор /Б.Баасансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Нарангэрэл/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 17 хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-72.Docx

1526191399



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1060/АДИ50458

Улаанбаатар хот

САГ - 2026/81/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулахаар төлөвлөсөн 371,514,337.78 гурван зуун далан нэгэн сая таван зуун арван дөрвөн мянга гурван зуун гучин долоон төгрөг далан найман мөнгө/ төгрөгийн хичээл, дадлагын өрөөний тавилга эд хогшилд нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 32 дугаар зүйлийн 32.1 "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ", 32.2 "Нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг энэ хуулийн 18.1-д заасны дагуу нийтэлнэ", 48 дугаар зүйлийн 48.4.2 "нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэл" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.10 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор /Б.Баасансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Нарангэрэл/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-72.Docx

1526191297



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1061/АДИ50458

Улаанбаатар хот

САГ - 2026/81/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургууль нь тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 27-ний өдөр 01/190 дүгээр албан бичгээр 12 хоног хугацаа хоцроож ирүүлсэн.

Энэ нь Төсвийн ухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж, тайлагнахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор /Б.Баасансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Нарангэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1062/АД150458

Улаанбаатар хот

САГ - 2026/81/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 3 байгууллагад үндсэн хөрөнгө, бараа материал бэлтгэхэд 55,220,000.00 /тавин таван сая хоёр зуун хорин мянган/ төгрөгийг шилжүүлж урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн боловч жилийн эцэст тооцоо хийж хөрөнгийг орлогод бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үндсэн хөрөнгө, бараа материал бэлтгэхтэй холбоотой урьдчилж гарсан зардлын дансны тооцоо хийдэггүй, хөрөнгийг бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор /Б.Баасансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Нарангэрэл/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1063/А0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/81/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн 2014-2016 онуудад үүссэн, өмнөх захиралтай холбоотой 461,560,000.00 /дөрвөн зуун жаран нэгэн сая таван зуун жаран мянган/ төгрөг, Стройка ХХК-ийн 151,519,300.00 /нэг зуун таван нэгэн сая таван зуун арван есөн мянга гурван зуун/ төгрөг, Соёмбо групп ХХК-ийн 83,500,000.00 /наян гурван сая таван зуун мянган/ төгрөг, нийт 696,579,300.00 /зургаан зуун ерэн зургаан сая таван зуун далан есөн мянга гурван зуун/ төгрөгийн авлага нь эзэн холбогдогч нь нас барсан, хаяг байршилдаа байхгүй, тодорхой бус шалтгаанаар авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эзэн холбогдогч нь нас барсан, хаяг байршилдаа байхгүй, тодорхой бус гэсэн шалтгаанаар авлагыг барагдуулаагүй байгаа зөрчлийг хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, ажил гүйлгээг гарахаас өмнө хянадаггүй, төлбөрийг шилжүүлдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор /Б.Баасансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Нарангэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\20260316 SAG-72.Docx

1526181791



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1064/А0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/81/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлаас чөлөөлөгдсөн нэр бүхий 12 ажилтнаас авах 5,769,680.69 /таван сая долоон зуун жаран есөн мянга зургаан зуун наян төгрөг жаран есөн мөнгө/ төгрөгийн цалингийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" -д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажлаас чөлөөлөгдсөн нэр бүхий 12 албан хаагчтай холбоотой цалингийн авлагыг барагдуулаагүй, тооцоо хийгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор /Б.Баасансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Нарангэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ

